

АНХААРАЛ ТАТСАН ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

Бодлого, дүн шинжилгээний баг

СЭДЭВ: ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АШИГЛАЛТ, ХЯНАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хүний Эрхийн Үндэсний Комиссын Стратеги төлөвлөгөөний Зорилт 2.1, 2008 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.1-д заасны дагуу химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хяналтын асуудлаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийснээ илтгэж байна.

Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, түүнд тавигдах хяналт нь иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхэд нөлөөлөх чухал хүчин зүйл тул ХЭҮК-ын гишүүд, ажилтнуудыг энэ талаарх мэдээллээр хангах нь багийн хувьд хийвэл зохих ажил юм.

Мэдээлэл цуглуулах ажиллагааг 2008 оны 2 дугаар сарын 1-нээс 3 дугаар сарын 15-ны дотор явуулсан бөгөөд энэхүү тайлангийн үндсэн мэдээллийг Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газраас авсан болно.

НЭГ. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АХИЦ ДЭВШИЛ

Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, хадгалах, дотооддоо тээвэрлэх, ашиглах, устгахтай холбогдсон гол харилцааг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна. Үүнд:

1. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
2. Химийн бодисын аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2000 оны 29 дугаар тогтоол
3. Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт”
4. Байгаль Орчны Сайд, Эрүүл Мэндийн Сайд, Онцгой Байдлын Асуудал Эрхэлсэн Сайдын хамтарсан 2007 оны 151/126/52 дугаар тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
7. Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт” зэрэг болно. (Холбогдох эрх зүйн хууль тогтоомжийн түүврийг хавсаргав.)

Сүүлийн үед химийн хорт болон аюултай бодисын талаарх эрх зүйн зохицуулалтад гарсан чухал өөрчлөлүүдийг нэрлэвэл:

- “Монгол Улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт”-д 30 бодис хамрагдаж байсныг 2007 онд 111 бодис болгож, тоо хэмжээг нэмэгдүүлсэн бөгөөд эдгээрийн 28 бодисын ашиглалтыг хязгаарлаж, 83-г бүрмөсөн хориглосон байна.
- Химийн хорт болон аюултай бодисын тухай 2006 оны шинэ хуулиар химийн хорт бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх,

- Иргэд химийн бодисын хор уршиг, зөв хэрэглээний талаар мэдээлэлтэй байж гэмээ нь эрхээ хамгаалж чадах билээ. Иргэдэд химийн хорт болон аюултай бодисын талаар мэдээлэл хүргэх, мэдээллийн нэгдсэн сан бий болгох үүргийг хуульд заасны дагуу Байгаль орчны яам хүлээсэн боловч биелэгдэхгүй байна. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль батлагдсанаас хойш тус яам химийн хорт бодисын аюулгүй ажиллагааны тухай нэг гарын авлага, шинэ хууль батлагдахаас өмнө хоёр гарын авлага тус тус гаргасан байсан байна. Гэвч тэдгээр гарын авлагыг хэдэн хувь гаргаж, хэрхэн түгээсэн талаар ямар нэг мэдээ баримт олдсонгүй. Түүнчлэн, мөн хуулийн 6.1.7-д зааснаар Байгаль орчны яам “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ” гэж заасан ч өнөөг хүртэл мэдээллийн нэгдсэн сан байгуулагдаагүй байна. Харин тус яамны төлөвлөгөөнд 2008 онд багтааж, 250 химийн бодисын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, цахим хуудсандаа байршуулахаар заажээ.
- Засгийн газрын 2000 оны 29 дугаар тогтоолын дагуу химийн хорт болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг устгах цэгийг 2000 оны 2-р улиралд багтаан аймаг нийслэлд тогтоож өгөх ёстой байсан боловч энэ ажил хийгдээгүй байна. Ялангуяа аюултай хог хаягдлын хуримтлал, бохирдол үүсч буй газруудын байршил, хог хаягдлын бөөгнөрөлийн хэмжээ, хамарсан талбай, хаягдлын талаар орон нутагт хийгдсэн ажил бага байгаа юм. Аюултай, хортой хог хаягдал гаргадаг эх үүсвэрүүдийн нэр, үйл ажиллагааны төрөл, үйлдвэр, аж ахуйн газруудаас гарч буй хаягдлын тухай анхан шатны мэдээ бүртгэлгүй байна.
- Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээнд хяналт тавих, иргэдийнхээ эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй байна. Үүний зэрэгцээ орон нутгийн удирдлагууд химийн хорт болон аюултай бодисыг зүй бусаар ашигладаг аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг хамгаалах, хаацаалах, зарим тохиолдолд өөрсдөө ийм үйлдэлд оролцож байгаа нь анхаарал татаж байна. Тэдгээр төрийн албан хаагчдад хариуцлага тооцож байгаа байдал хангалтгүй байна.

Шугтгээ 2

Төв аймгийн Борнуур сумын засаг дарга Ц.Гүнбаатар тус сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Гүнбилэг трейд” ХХК-ний Харганы уурхайд нэг ч тээрэм байхгүй, ажлын хэсэг тийш явах шаардлагагүй гэж танилцуулж байсан ч тухай компанид 5 тээрэм устгалд ороогүй хадгалагдаж байсан нь Засаг даргын захирамж гаргуулах тухай ажлын хэсгийнхний тавьсан шаардлагыг хүлээн авахаас зайлсхийсэн байна.

Дархан-Уул аймгийн Дархан сум дахь Орд Харш ХХК-ийн объектод хууль бусаар тээрэм ажиллуулан ихээхэн хэмжээний бохирдол үүсгэсэн иргэн Т.Батмөнхөд эрүү үүсгүүлэн шалгуулсан боловч 2007.08.15-ны өдөр хэрэгсэхгүй болгожээ.

Хонгор суманд ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрөлтэй Голден проект ХХК, Лоток ХХК-нууд химийн хорт бодис зөвшөөрөлгүй хэрэглэж хөрс бохирдуулсан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр цагдаагийн байгууллагад хүргүүлсэн боловч лицензийн талбайгаас илэрсэн нь тогтоогдоогүй учир эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

ЛУМХГ-ын гүйцэтгэлийн шалгалтын тайлангаас – 2008 он/

- Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр оруулах эрх бүхий 6 боомт улсын хэмжээнд байгаа боловч тэдгээрт мэргэшсэн боловсон хүчин, тоног төхөөрөмж дутагдалтайгаас хуулийн хэрэгжилт хангалттай байж чадахгүй байна.

Шигтгээ 3

Иргэн Ц.Монгол, Ш.Пүрэвсүрэн болон нэр бүхий 336 иргэн Үндсэн хуулийн цэцэд: Монгол Улсын Засгийн газрын “Тогтоолд нэмэлт оруулах тухай” 65 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан эрхийг зөрчсөнийг тогтоолгох тухай өргөдөл гаргасан байна. Учир нь Засгийн газар нь энэхүү тогтоолыг гаргахдаа уг химийн хорт бодис нэвтрүүлэх шинээр баталсан хоёр боомтыг мэргэжлийн боловсон хүчнээр болон зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаагүй нь Монгол Улсын хилээр их хэмжээний, онц аюултай химийн хор /цианит натри, мөнгөн ус зэрэг/ хяналтгүйгээр нэвтрэх нэг нөхцлийг бүрдүүлсэн байна гэжээ. Цэцийн дүгнэлтэд гаалийн ажилтан энэ дүгнэлтийг зөвшөөрсөн тухай тэмдэглэгдсэн байна.

/ Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 02 дугаар дүгнэлтээс/

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН АШИГЛАЛТ, ХЯНАЛТ

Байгаль орчны яам 2007 онд давхардсан тоогоор 196 аж ахуйн нэгж байгууллагад химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, худалдах, үйлдвэрлэх зөвшөөрлийг олгожээ. Цианид ашиглах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн тоо 2006 онд 9 байсныг цөөлж, 2007 онд натрийн цианидийн “импортлох, ашиглах” зөвшөөрлийг 3², “ашиглах” зөвшөөрлийг нэг³ аж ахуйн нэгжид олгосон байна. /Хавсралт 2-ийг үзнэ үү./ Химийн бодисын ашиглалтыг хянах зорилгоор Байгаль орчны яам 2 жил тутамд улсын үзлэг тооллого явуулж байна. Түүнчлэн мэргэжлийн хяналтын байгууллагаас гэнэтийн хяналт шалгалт хийдэг.

2000 оноос хойш Байгаль орчны яам химийн бодисын улсын үзлэг тооллогыг 4 удаа явуулсан байна. 2007 оны үзлэг тооллогын нэгдсэн дүнгээр улсын хэмжээнд бүртгэгдсэн химийн бодисын 70 орчим хувь нь Улаанбаатар хот, Ховд аймагт, 24 орчим хувь нь Орхон аймагт байгаа тухай тэмдэглэгдсэн байна. Харин энэ тооллогоор аж үйлдвэр, эрүүл мэнд, боловсрол зэрэг салбаруудад химийн бодисын хэрэглээ ямар байгаа талаар дүн гаргаагүй байна. Энэ нь тооллого зөвхөн үйлдвэрлэл, уул уурхайн салбараар хязгаарлагдаж болзошгүй байгаа юм.

2007 оны жилийн эцсийн байдлаар Улсын хэмжээнд нийт 944 нэр төрлийн химийн бодис бүртгэгдэн 8368959.2 кг үлдэгдэл нөөцтэй байна. Үүнийг аймаг, нийслэл тус бүрээр товчоолон, хэмжээг харуулбал:

д/д	Аймаг, нийслэлийн нэр	Химийн бодисын нэр төрөл	Үлдэгдэл нөөц, кг	Нийт бодист эзлэх, хувь
1	Архангай	161	356.4	0.00
2	Баян-Өлгий	5	18932.0	0.23
3	Баянхонгор	56	2663.9	0.03

² Бороо Гоулд ХХК, Эм Жи Эйч ХХК, Тэн Хун ХХК

³ Бумантрейд ХХК

4	Булган	66	73022.0	0.87
5	Говь-Алтай	25	6556.8	0.08
6	Говьсүмбэр	29	3661.8	0.04
7	Дархан-Уул	88	74303.5	0.89
8	Дорнод	56	31983	0.38
9	Дорноговь	38	36429.4	0.44
10	Дундговь	31	9207.6	0.11
11	Завхан	106	1382.5	0.02
12	Орхон	225	1303945.3	15.58
13	Өвөрхангай	46	5597.3	0.07
14	Өмнөговь	19	49269.2	0.59
15	Сүхбаатар	86	541445.8	6.47
16	Сэлэнгэ	133	389540.0	4.65
17	Төв	167	5337.6	0.06
18	Увс	73	1861.3	0.02
19	Ховд	191	2881659.9	34.43
20	Хөвсгөл	48	986.7	0.01
21	Хэнтий	28	93551.8	1.12
22	Улаанбаатар	757	2837265.0	33.9
	БҮГД	944	8368959.2	100.0

Монгол улсад ашиглахыг хориглосон альдрин, гексахлорбензол, дильдрин 3 төрлийн бодис Хөвсгөл, Улаанбаатарт нийт 18.5 кг үлдэгдэлтэй байна гэсэн тооллогын дүн гарсан нь хууль бусаар химийн бодис хилээр нэвтэрч байгааг харуулж байна.

Монгол улсын хэмжээнд химийн бодисын хэрэгцээ, нийт төрлийг бүрэн гаргаж чадахгүй байна. Үүнийг Байгаль орчны яам дараах шалтгаантай холбон тайлбарлаж байгаа юм. Үүнд

- Аж ахуйн нэгж, байгууллагын дийлэнх нь химийн бодисыг үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд, материал болон ашигладаггүйгээс жилийн хэрэгцээгээ төлөвлөж, бүртгэл тайландаа тусгаагүй
- Судалгаа, шинжилгээ, сургалтын зориулалтаар хэрэглэдэг тул тухай бүр шаардлагатай үед бодис, урвалжийг худалдан авдаг
- Жилийн эцэст үзлэг тооллого болсон нь химийн бодисын үлдэгдэл бага байгаа
- Аж ахуйн нэгж, байгууллагын химийн бодисын орлого, зарлагын бүртгэл зохих журам, дүрмийн дагуу хөтлөгдөхгүй, урсгалаар явж байгаа

Мөн химийн хорт болон аюултай бодисыг хууль бусаар ашиглаж байгаа далд сүлжээ нь өөрсдийн хэрэглэж буй бодис нь ямар нэртэй бодис болох, хор, аюул нь хэрхэн нөлөөлөх шинж чанартайг мэдэхгүй, зөвхөн олз ашиг, мөнгө олох зорилгоор нууцаар хэрэглэж буй нь улсын дүн бүртгэлд орохгүй гол шалтгаан болж байна. Иймээс аймаг, орон нутгаас ирүүлсэн үзлэг, тооллогын анхан шатны мэдээлэлд уул уурхай, алт угаах үйл ажиллагаанд хэрэглэж байгаа мөнгөн ус, цианид нэгдлийн болон бусад химийн бодисын тухай, аюултай хортой хог хаягдлын хэмжээ, эзлэх талбай, бохирдсон газар нутгийн тухай анхан шатны тоо баримтууд байхгүй байгаа юм. Энэ нь иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчигдөхөд хүргэж, иргэдийн эрүүл мэнд, амь нас хохироход ойрхон буйг харуулж байна. Эдгээр анхан шатны тоо баримт байхгүй нөхцөлд иргэдийн эрхийг хамгаалахад хүндрэл учрах боломжтой.

“Химийн бодис ашиглан алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа”-нд Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Онцгой байдлын ерөнхий

газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан үзлэг, шалгалтыг 2008 оны 2 дугаар сард нийт 21 аймгийн нутагт явуулж, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Булган, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт мөнгөн ус хууль бусаар ашиглан алтны хүдэр тээрэмдэн алт ялгах үйл ажиллагаа явуулж байсан 145 тээрмийг илрүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг зогсоон, иргэд аж ахуйн нэгжээс 35 кг мөнгөн ус, 1200 кг натрийн цианидийн хураан авсан байна.

Химийн бодис хэрэглэдэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын технологийн төвшин олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцэхгүй байна. Химийн бодис хэрэглэгчийн химийн бодис тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалтын болон ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартын шаардлагад хүрээгүй, Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн хуралдаанаар өгөгдсөн үүргийн дагуу байгуулагдсан ажлын хэсгээс тухайн аймагт алт олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хийсэн улсын үзлэгээр илэрсэн зөрчлийн байдлыг арилгуулах ажлын үр дүнг үнэлж, ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт муу байна. Химийн бодисын импорт, дотоод худалдааны үйл ажиллагааг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрс сайжруулах шаардлагатай болсон байна. Аймаг орон нутагт Монгол Улсын химийн чиглэлийн олон улсын конвенц, түүнийг хэрэгжүүлэхээр үндэсний хэмжээнд хүлээсэн үүрэг, НҮБ-ын төрөлжсөн байгууллагад гаргаж өгөх мэдээ, бүртгэлийн талаар ойлголтогүй байна гэж Байгаль орчны яамнаас хийсэн улсын үзлэг тооллогын тайланд дүгнэсэн байна.

Мөн нийт аймаг, сум, орон нутгуудад химийн хорт бодисын ашиглалт, хадгалалтын талаар дараахь нийтлэг зөрчлүүд одоог байгааг Улсын мэргэжлийн хяналтын газар тэмдэглэж байна.

- Онцгой хортой химийн бодис мөнгөн ус, цианид натриар бохирдсон шлам, хөрс бүхий газруудад хийгдсэн хамгаалалтын хашаа нь нурж унасан, хулгайд алдагдсан;
- Хууль бусаар мөнгөн усны тээрэм ажиллуулсан болон цианжуулсны улмаас хорт бодисоор бохирдсон байх магадлалтай ундны усны эх үүсвэрүүдийг хамгаалалтанд авч, хашаажуулаагүй, лабораторийн нарийвчилсан шинжилгээнд хамруулаагүй;
- Үндсэн ордны алтны агуулга бүхий чулуунаас хууль бусаар олборлолт явуулж буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй;
- Хавирга зэрэг химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох зөвшөөрөлгүй хилийн зарим боомтуудаар шингэрүүлсэн хий, химийн бодис, тэсрэх материал нэвтрүүлж байгаа;
- Хилийн зарим боомтууд нь химийн бодисын импорт, экспортод шинжилгээ хийх лабораторигүйгээс нүдэн баримжаагаар хяналт тавьдаг;
- Цацраг идэвхит бодисын үүсвэрүүдийг хилээр оруулж, буцаан гаргахтай холбогдсон баримт бичгийн бүрдүүлэлт, түүнд тавих хяналт хангалтгүй;
- Хэрэгжиж буй зарим төслийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа уусган баяжуулах үйлдвэрүүд үйлдвэрийн болон хаягдлын ахуйн зураг төсөлгүй, уг технологийг лабораторийн нөхцөлд туршсан туршилтын баримт бичиггүй, химийн бодисын хэрэглээний нарийвчилсан тооцоо судалгаагүй, үйлдвэрийг ашиглалтанд хүлээн авсан эрхийн актгүйгээр үйл ажиллагаа явуулсан;

- Хилийн бүс нутгийн ойролцоо химийн бодис ашигласан үйл ажиллагаа явуулж буй зарим томоохон аж ахуйн нэгжүүдийн химийн бодисын бүртгэл тооцоо муу, хадгалж байгаа нөхцөл нь шаардлага хангаагүй;
- Онцгой хортой химийн бодис мөнгөн ус, цианид натрийг хууль бусаар ашиглан хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол үүсэх нөхцөл бүрдүүлсэн, их хэмжээний бохирдол үүсгэсэн иргэд, аж ахуйн нэгжтэй холбоотой эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон;
- Химийн хорт бодисыг устгах цэгийг тодорхой заагаагүй байна.

Химийн хорт болон аюултай бодисын зохисгүй хэрэглээ хүний эрхийг зөрчиж байна хэмээн үзсэн иргэд болон иргэдийн хөдөлгөөнүүд эрх ашгаа хамгаалахаар идэвхтэй ажиллаж байна. Байгаль орчны яамнаас 2007 онд цианит натри ашиглах зөвшөөрөл авсан Тэн Хун ХХК-ийн зөвшөөрлийг эсэргүүцсэн Төв аймгийн Жаргалант сумын иргэд “Жаргалант нутгаа аваръя” нэртэй хөдөлгөөнийг байгуулан идэвхтэй тэмцсэний үр дүнд цианит натри ашиглах зөвшөөрлийг хүчингүй болгосон юм. Тухайн асуудал дээр Байгаль орчны яам сумын төвөөс 5 км, тариан талбайгаас 3 км зайд ашиглах зөвшөөрөл олгосон байсан бөгөөд Жаргалант сум нь тариалангийн бүс нутаг тул онцгой хортой химийн хорт бодис ашигласнаар сумын иргэдийн газар тариалангийн аж ахуйд сөрөг нөлөөлөл гарна гэж үзсэн.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Мэдээлэл цуглуулах ажиллагааны дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улс дахь химийн хорт болон аюултай бодис нь төрийн байгууллагын хатуу хяналт, дагаж мөрдөх стандартуудын дагуу ашиглагдах ёстой бөгөөд энэ нь хангалтгүй хэрэгжиж байна. Холбогдох байгууллагуудаас хяналт шалгалтыг явуулж байгаа ч үр дүн муутай, байгаа зөрчил дутагдлыг дурдах төдийн өнгөрч, түүнийг арилгуулах арга хэмжээ авахад хангалтгүй ажиллаж байна.
- Химийн хортой, аюултай бодисын хэрэглээг зохицуулах, хордлогоос хүн амыг хамгаалах талаар хуулиар олгогдсон эрх үүргээ аймаг орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтан хэрэгжүүлэхгүй, хордлого, бохирдол үүсгэх боломж олгосон этгээдтэй хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцохгүй орхигдуулснаас мөнгөн ус, цианидын хууль бус хэрэглээг өргөжүүлэхэд хүргэсэн байна.
- Химийн хорт болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон химийн хорт бодисыг устгах цэгийг 2000 оны хоёрдугаар улиралд багтаан тогтоож өгөхийг Засгийн газрын 201 дүгээр тогтоолд заасан боловч найман жилийн хугацаанд энэ ажил хийгдээгүй байна. Химийн бодисын үлдэгдэл, хортой, аюултай хог хаягдлын хуримтлал үйлдвэр, үйлчилгээний байгууллагад бий болж олон жил хадгалагдаж байгаа нь бас нэг аюулын эх үүсвэр болж байна.
- Химийн хорт бодисын хэрэглээ, хадгалалт, ашиглалтын тайланг аж ахуйн нэгж, байгууллагууд Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7-д заасны дагуу сар бүрийн 1 дүгээр сарын дотор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 11 дүгээр сарын 15-нд сум, дүүргийн Засаг даргад

хүргүүлэх үүрэгтэй байдаг хэдий ч энэ нь хангалтгүй хэрэгждэг. Тайланг ирүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцдоггүй, тооцож байсан тохиолдол байдаггүй байна.

- Химийн хорт болон аюултай бодисын нэгдсэн мэдээллийн сан байгуулагдаагүй байгаа нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг энэ талын хэрэгцээт мэдээллээр хангагдахад хүндрэл учруулж байна.
- Химийн бодис нэвтрүүлдэг хилийн боомтууд болон түр боомтууд дээр гаалийн мэргэжлийн байцаагч, шалгах багаж хэрэгсэл, шинжлэх лабораторийн хүчин чадал байхгүйгээс химийн бодист тавих хилийн хяналт сул, шаардлага хангахгүй байгаа нь хилээр хууль бусаар химийн бодис нэвтрэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

ДӨРӨВ. САНАЛ

Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, хяналтын асуудлаар хийсэн дүн шинжилгээнд үндэслэн Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу мэргэжлийн байгууллагын хяналтыг сайжруулах, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн зөвлөмж боловсруулж, Засгийн газар, Байгаль орчны яам, Улсын мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэх саналыг Комиссын гишүүдийн хуралд оруулж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХИМИЙН БОДИСЫН 2007 ОНЫ УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ ТАЙЛАН

Нэг. Химийн бодис ашиглах үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Химийн бодисын ашиглалтаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихэссэнтэй холбогдуулан эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох талаар сүүлийн жилүүдэд төр, засгаас хэд хэдэн бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

УИХ-ын 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар “Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд уг хуулийн хэрэгжилтийг хангах, химийн бодисын хэрэглээ, импортод тавих хяналтыг чангатгах зорилгоор Засгийн газрын тогтоол, журам, дүрэм, хамтарсан сайдын тушаалыг гарган мөрдүүлж эхлээд байна.

“Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль” болон “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-ын 2008 оны 1 дүгээр сарын 3-ний өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн батлан гаргав. Энэхүү хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр химийн бодисын ангиллыг НҮБ-ын баталсан жишигт нийцүүлэх, химийн бодисын зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгон нэгдсэн тоо бүртгэлийн системд оруулан төрийн захиргааны төв байгууллагаас хяналт тавих боломжийг олгож байна.

Химийн хортой, аюултай бодисын тухай хуулийн дагуу химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудлаар мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий “Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл”-ийг Ерөнхий сайдын дэргэд шинээр байгуулж, бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор баталснаар химийн бодисын ашиглалтын салбар дундын зохицуулалтыг сайжруулах нэг чухал алхам болсон.

“Монгол улсад ашиглахыг хориглосон буюу хязгаарласан химийн бодисын жагсаалт”-ыг Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, уг жагсаалтад 30 бодис хамрагдаж байсныг бодит байдалд нийцүүлэн хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой 111 бодисыг оруулсан бөгөөд эдгээрээс 28 бодисын ашиглалтыг хязгаарлаж, үлдсэн 83-г бүрмөсөн хориглохоор шийдвэрлэсэн юм.

Химийн бодисыг экспортлох, импортлох, үйлдвэрлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах зөвшөөрлийг аймаг, яамд олгодог байсан тогтолцоог хуулийн өөрчлөлтөөр байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар олгохоор болсон нь химийн бодисын ашиглалтад тавигдах аюулгүй ажиллагааны шаардлагыг өндөржүүлж, химийн хорт болон аюултай бодисыг ашиглагч аж ахуйн нэгж, иргэдийн байршил, хаяг болон химийн бодисын нэр төрөл, тоо хэмжээ, зориулалт, үүсэх болзошгүй эрсдлийн магадлал зэрэг мэдээлэл бүртгэлийн нэгдсэн тогтолцоо бий болж, хяналт тавихад дөхөм болжээ.

Байгаль орчны яам 2007 онд давхардсан тоогоор 196 аж ахуйн нэгж байгууллагад химийн хорт болон аюултай бодис импортлох, ашиглах, худалдах, үйлдвэрлэх зөвшөөрлийг олголоо. Химийн бодист зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг чангатган, хяналтыг сайжруулж, холбогдох байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах бололцоо бүрдсэн бөгөөд үүний нэг илрэл нь цианид ашиглах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн тоо 2006 онд 9 байсныг цөөлж, 2007 онд натрийн цианидын “импортлох, ашиглах” зөвшөөрлийг 3, “ашиглах” зөвшөөрлийг нэг аж ахуйн нэгжид олгоод байна.

“Химийн бодис ашиглан алт олборлож буй иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа”-нд Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Онцгой байдлын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан үзлэг, шалгалтыг 21 аймгийн нутагт явуулж, Төв Сэлэнгэ, Дархан-Уул,

Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Булган, Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт мөнгөн ус хууль бусаар ашиглан алтны хүдэр тээрэмдэн алт ялгах үйл ажиллагаа явуулж байсан 145 тээрмийг илрүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг зогсоон, иргэд, аж ахуйн нэгжээс 35 кг мөнгөн ус, 1200 кг натрийн цианид хураан авч тэдгээр бодисоос байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг зогсоосон байна.

Үзлэг, шалгалтын нэгдсэн дүнг Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дараахь арга хэмжээ авахыг холбогдох яам, байгууллагад үүрэг болгосон шийдвэрийг гаргалаа. Үүнд:

- мөнгөн усыг ашигт малтмалын олборлолт, боловсруулалтад ашиглахыг хориглох;

- мөнгөн ус, цианидаар бохирдсон хаяглын хэмжээ, тархалтын хязгаарыг тогтоож хоргүйжүүлж булшлах оновчтой аргыг боловсруулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

- аюултай хог хаягдал устгах төвлөрсөн байгууламж, агуулах байгуулах талаар санал боловсруулан Засгийн газарт оруулж хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зэрэг болно. Засгийн газрын 201 дүгээр тогтоол болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор лабораториудын чадавхийг сайжруулах санал боловсруулах, мөн мөнгөн ус, цианидаар бохирдсон шламыг боловсруулж, хоргүйжүүлэх талаар технологи боловсруулах, стандартуудыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор натрийн цианид, мөнгөн усны сөрөг нөлөөлөл үүсч байгаатай холбогдуулан хорт бодисын тун хэмжээг нарийвчлан тодорхойлох чадвар бүхий хүнсний бүтээгдэхүүн дэх мөнгөн ус тодорхойлогч багаж худалдан авахад шаардагдах 60 мянган ам. долларыг Засгийн газрын нөөц сангаас гаргах шийдвэр гарган тус багажийг импортоор авч улсын мал эмнэлгийн төв лабораторит суурилуулсан байна.

Химийн бодист тавих хяналтыг сайжруулах, хууль бус импортыг зогсоох зорилгоор химийн бодисыг түр болон байнгын 18 боомтоор улсын хилээр нэвтрүүлж байсныг зогсоож, Засгийн газрын 2006 оны 296 дугаар тогтоолоор Дорноговь аймаг дахь Замын-Үүдийн боомт, Сэлэнгэ аймаг дахь Алтанбулаг, Сүхбаатар боомт, Буянт-Ухаа дахь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хилийн шалган нэвтрүүлэх боомт гэсэн 4 боомтоор импортлох боллоо. Газрын тосны хайгуулын ажилтай холбоотойгоор Үйлдвэр худалдааны яамны саналаар Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 65 дугаар тогтоолоор Дорнод аймгийн Баянхошууны боомт, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтыг тус тус нэмж баталсан бөгөөд энэ 2 боомтоор зөвхөн Петрочайна Дайчин Тамсаг ХХК-ийн химийн бодисыг оруулах зөвшөөрлийг олгосон байна.

“Мөнгөн ус, цианидаар бохирдсон хаягдлыг хамгаалалтанд авах арга хэмжээний тухай” Байгаль орчны сайд, Химийн үндэсний зөвлөлийн даргын 2007 оны 03 тоот албан даалгаврыг гаргаж, хорт бодис бүхий алтны хүдрийн овоолготой аймаг, сумдуудад хүргүүлэн мөнгөн усны ууршилт, тархалтыг бууруулах, хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Химийн үндэсний зөвлөлийн ажилд мэргэжлийн туслалцаа үзүүлэх шинжээчдийн багийг Байгаль орчны сайдын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлан ажиллуулж байна. Үндэсний зөвлөлийн шинжээчдийн баг Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт үүссэн мөнгөн ус, цианидын бохирдлыг хоргүйжүүлж, саармагжуулах үйл ажиллагааг зохион байгуулж, үүссэн нөхцөл байдалд байнгын хяналт шинжилгээ хийх аргачлал, ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Химийн хорт бодисын сөрөг нөлөөнд өртсөн Дархан-Уул аймгийн Хонгор сум болон аюул осол гарч болзошгүй анхаарал татсан газар нутагт цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг боловсруулах талаар УИХ-ын холбогдох байнгын хороодтой Химийн үндэсний зөвлөл хамтран шуурхай ажиллаж байна.

Газар тариалан, ургамал хамгаалал, мал эмнэлгийн салбарт ашиглах пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн зориулалт бүхий химийн бодисын жагсаалтууд, тэдгээрийн хэрэглэх хэмжээг Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуй, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2007 оны 97/39/79 тоот тушаалаар баталгаажуулан мөрдөж байна.

Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг Байгаль орчин, Эрүүл мэнд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 151/126/ 52 дугаар хамтарсан тушаалаар батлан мөрдүүлж эхлэв.

“Полихлорт бифенил зэрэг удаан задардаг органик бохирдуулагчийн хэрэглээг байгаль орчинд халгүй орлуулагчаар солих менежментийг чадавхийг бий болгох”, “Эмнэлэгийн хог хаягдлын менежментийг сайжруулах” төслүүдийн саналыг боловсруулж, Даян дэлхийн байгаль хамгаалах санд өргөн бариад байна.

УИХ-ын 2007 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-д “Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс, усыг хоргүйжүүлэх арга хэмжээ авах, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх”-эд зориулж улсын төсвөөс 300 сая төгрөг зарцуулахаар тусган хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг эхлээд байна.

Хоёр. Химийн бодисын үзлэг, тоологын дүн

Байгаль орчны сайд, Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн даргын 2007 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 197 дугаар тушаалаар батлагдсан Үзлэг тооллогын төв комисс “Химийн бодисын ашиглалт, аюултай, хортой хог хаягдлын улсын үзлэг тооллого”-ыг 2007 оны 7 сараас эхлэн улсын хэмжээнд удирдан зохион явуулав.


Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, “Химийн бодисын ашиглалт, аюултай, хортой хог хаягдлын улсын үзлэг, тооллого”-ыг зохион байгуулах төв комиссын даргын 2007 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 58 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын дэд хэсгүүд 21 аймаг, нийслэлд ажиллаж, химийн бодисын ашиглалт, аюултай хог хаягдлын үзлэг тооллогыг аж ахуйн нэгж, байгууллагад хийж, аймаг, нийслэлийн анхан шатны дүн материалыг Байгаль орчны яаманд ирүүлж, эдгээр материалыг нэгдсэн илтгэл, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсэг нэгтгэн эцсийн тайлан, мэдээг нэгтгэн гаргалаа.

Үзлэг, тооллогод нийслэл, 21 аймгийн химийн бодис хэрэглэдэг аж ахуйн нэгж, байгууллага хамрагдав. Химийн бодисын нэгдсэн дүн, Монгол улсад ашиглахыг хязгаарласан, хориглосон бодиын тухай дүн мэдээг 1, 2, 3 дугаар хавсралтад үзүүлэв.


Улсын хэмжээнд нийт 944 нэр төрлийн химийн бодис бүртгэгдэж, 8368959.2 кг үлдэгдэл нөөцтэй байна. Үүнийг аймаг, нийслэл тус бүрээр товчоолон, тэдгээрийн хэмжээг харуулбал:

д/д	Аймаг, нийслэлийн нэр	Химийн бодисын нэр төрөл	Үлдэгдэл нөөц, кг	Нийт бодист эзлэх, хувь
1	Архангай	161	356.4	0.00
2	Баян-Өлгий	5	18932.0	0.23
3	Баянхонгор	56	2663.9	0.03
4	Булган	66	73022.0	0.87
5	Говь-алтай	25	6556.8	0.08
6	Говьсүмбэр	29	3661.8	0.04
7	Дархан-Уул	88	74303.5	0.89
8	Дорнод	56	31983	0.38
9	Дорноговь	38	36429.4	0.44

10	Дундговь	31	9207.6	0.11
11	Завхан	106	1382.5	0.02
12	Орхон	225	1303945.3	15.58
13	Өвөрхангай	46	5597.3	0.07
14	Өмнөговь	19	49269.2	0.59
15	Сүхбаатар	86	541445.8	6.47
16	Сэлэнгэ	133	389540.0	4.65
17	Төв	167	5337.6	0.06
18	Увс	73	1861.3	0.02
19	Ховд	191	2881659.9	34.43
20	Хөвсгөл	48	986.7	0.01
21	Хэнтий	28	93551.8	1.12
22	Улаанбаатар	757	2837265.0	33.9
	БҮГД	944	8368959.2	100.0




Зураг 1. 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, хэмжээ %




Зураг 2. 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, нэр төрлийн тоо

Улсын хэмжээнд бүртгэгдсэн химийн бодисын 80 гаруй хувь нь Улаанбаатар хот, 24 орчим хувь нь Орхон аймагт байгаа нь үйлдвэр, аж ахуйн нэгж болон боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагууд төвлөрөлтэй холбоотой байна.



Зураг 3. Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтаас 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, хэмжээ (%)



Зураг 4. Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтаас 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, хэмжээ (%)

Монгол улсад ашиглахыг хязгаарласан 25 нэр төрлийн бодис Баян-Өлгий, Дорноговь, Хэнтий аймгаас бусад аймаг, нийслэлд 0.4-28131.4 кг үлдэгдэлтэй нөөцтэй байгаагийн 70 гаруй хувь нь Өмнөговь, Сэлэнгэ аймагт ногдож байна. Үүнд: Олон улсын хэмжээнд болон Монгол улсад хориглосон буюу хязгаарласан химийн бодисын үлдэгдэл Архангай аймагт нийт 3 нэр төрлийн 0.4 кг, Баянхонгор аймагт нэг төрлийн 50.1 кг, Булган аймагт нэг төрлийн 5.6 ткг, Говь-Алтай аймаг 2 төрлийн 0.8 кг, Говьсүмбэр аймагт нэг төрлийн 0.1 кг, Дархан-Уул аймагт нэг төрлийн 100 кг, Завхан аймагт нэг төрлийн 0.1 кг, Өмнөговь аймагт 2 төрлийн 27301 кг, Сэлэнгэ аймагт 2 төрлийн 1428.1 кг, Төв аймагт 4 төрлийн 140.8 кг, Ховд аймагт 4 нэр төрлийн 4.3 кг, Хөвсгөл аймагт 3 төрлийн 15.3 кг, Улаанбаатар хотод 7 төрлийн 106.58 кг бодисууд тус тус бүртгэгдэв.



Зураг 5. Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтаас 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, хэмжээ (кг)



Зураг 6. Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтаас 2007 оны Химийн бодисын улсын тооллогоор бүртгэгдсэн химийн бодисуудын нэгдсэн дүн, хэмжээ (кг)

Монгол улсад ашиглахыг хориглосон альдрин, гексахлорбензол, дильдрин 3 төрлийн бодис Хөвсгөл, Улаанбаатарт нийт 18.5 кг үлдэгдэлтэй байгаа нь үзлэгээр тогтоогдлоо.

Химийн бодисын үзлэг тооллогын дүн нь аж ахуйн нэгж, байгууллагын лаборатори, агуулахад байгаа үлдэгдэл нөөцийг тоолсон анхан шатны тоо баримтад тулгуурласан тул улсын хэмжээний бодисын хэрэгцээ, нийт нэр төрлийг бүрэн гаргах боломжгүй нь дараах учир шалтгаантай холбоотой байна. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын дийлэнхи нь химийн бодисыг үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд, материал болгон ашиглагдахгүйгээс жилийн хэрэгцээгээ төлөвлөж, бүртгэл тайландаа тусгаагүй;
- Судалгаа, шинжилгээ, сургалтын зориулалтаар хэрэглэдэг тул тухай бүр шаардлагатай үед бодис, урвалжийг худалдан авдаг;
- Жилийн эцэст үзлэг тооллого болсон нь химийн бодисын үлдэгдэл бага байгаа;
- Аж ахуйн нэгж, байгууллагын химийн бодисын орлого, зарлагын бүртгэл зохих журам, дүрмийн дагуу хөтлөгдөхгүй, урсгалаар явж байгаа зэрэг болно.

Түүнчлэн химийн бодис, бүтээгдэхүүн, материал, эм бэлдмэл, будаг, шатахуун, тослох материал, цавуу, холбогч, идээлэгч, барьцалдулагч, өнгөлөгч материал зэргийг хэрэглэгч бүр ангилж бүртгэдэггүй, химийн бодисыг гол тодорхойлдог химийн томъёо хаяг, шошго дээр байхгүй, химийн бодисыг худалдаалахад зайлшгүй дагах ёстой химийн тухайн бодисын хор, аюулын тухай лавлагааны бичиг баримт байхгүй зэрэг нь тооллогыг үнэн зөв үнэлж дүгнэхэд хүндрэл учруулж байгааг зориуд тэмдэглэж байна.

Химийн бодисыг хууль бусаар ашиглаж байгаа далд сүлжээ нь ямар нэртэй бодис болох, хор, аюул нь хэрхэн нөлөөлөх шинж чанартайг түүнтэй харьцаж байгааг хэрэглэгч мэдэхгүй, зөвхөн өнөөдрийн олз ашиг, мөнгө олох зорилгоор нууцаар хэрэглэж буй нь дүн бүртгэлд тэдгээр орохгүй үлдэх гол шалтгаан болж байна.

Учир иймээс аймаг, орон нутгаас ирүүлсэн үзлэг, тооллогын анхан шатны мэдээлэлд уул уурхай, алт угаах үйл ажиллагаанд хэрэглэж байгаа мөнгөн ус, цианид нэгдлийн болон бусад химийн бодисын тухай болон аюултай, хортой хог

хаягдлын хэмжээ, эзлэх талбай, бохирдсон газар нутгийн тухай анхан шатны тоо баримт байхгүй байна.

Химийн үзлэг, тооллогын анхан шатны тоо бүртгэлээс үзэхэд аймаг орон нутагт Монгол улсын химийн чиглэлийн олон улсын конвенциэр хүлээсэн үүргийн биелэлт тун тааруухан байгаа нь ажиглагдаж байна.

Үзлэгийн явцад дараахи асуудалд анхаарах шаардлагатай нь ажигдлаа. Үүнд:

- Химийн бодисын хор аюулын тухай мэдээлэлгүйгээс ямар осол, аюултай бодистой харьцаж байгаагаа мэдэхгүйгээс, аюулгүй ажиллагааны зохих ёсны шаардлагыг ажлын байранд бүрэн хангаагүйгээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх гол шалтгаан болж байна.
- Химийн бодис хадгалах зориудын агуулахгүй, химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлгүй, хаяг, шошгогүйгээс бодисын нэр төрлөө мэдэхгүй зөвхөн техникийн нэрээр нэрлэх буюу өөрсдөө үл тайлах үсгээр товчилсон зэрэг тохиолдлууд зонхилох хандлагатай байна.
- Химийн бодистой аюулгүй ажиллах талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудын мэдлэг туйлын ядмагаас туйлын хортой, аюултай бодисыг үйлдвэрлэл, ахуйн үйл ажиллагаанд дур зоргоороо хэрэглэснээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлж байна.
- Аймгуудын байгаль орчны албадад болон мэргэжлийн хяналтын газруудад химийн мэргэжлийн боловсон хүчин дутмаг, ихэнх аймгуудын алба химийн мэргэжилтэнгүй байсаар байна.

Химийн бодис хэрэглэж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудын химийн зөв зохистой бодисын хадгалалт, хамгаалалт, ашиглалт, устгалын үйл ажиллагаа хууль, тогтоомжид заасан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байна.

“Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөх аргачилсан заавар” (Байгаль орчны сайдын 2000 оны 45 дугаар тушаалаар баталсан) болон Үндэсний статистикийн газрын даргын 2000 оны 41 тоот тушалаар зөвшөөрч, Байгаль орчны сайдын 2000 оны 45 дугаар тушаалаар баталсан Химийн бодисын бүртгэлийн маягтуудын дагуу үйлдвэр, аж ахуйн нэгж бүрэн хөтлөхгүй байна.

Монгол Улсын Химийн чиглэлийн олон улсын конвенцийн хэрэгжилт тухайн аймаг, орон нутагт хангалтгүй байна.

Аюултай, хог хаягдлын хуримтлал, бохирдол үүсч буй газруудын байршил, хог хаягдлын бөөгнөрөлийн хэмжээ, хамарсан талбай, хаягдлын талаар орон нутагт хийгдсэн ажил бага байна. Аюултай, хортой хог хаягдал гаргадаг эх үүсвэрүүдийн нэр, үйл ажиллагааны төрөл, үйлдвэр, аж ахуйн газруудаас гарч буй хаягдлын тухай анхан шатны мэдээ бүртгэлгүй байна.

Химийн бодис хэрэглэдэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын технологийн төвшин олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцэхгүй байна.

Химийн бодис хэрэглэгчийн химийн бодис тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалтын болон ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартын шаардлагад хүрээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн хуралдаанаар өгөгдсөн үүргийн дагуу байгуулагдсан ажлын хэсгээс тухайн аймагт алт олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хийсэн улсын үзлэгээр илэрсэн зөрчлийн байдлыг арилгуулах ажлын үр дүнг үнэлж, ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт муу байна.

Химийн бодисын импорт, дотоод худалдааны үйл ажиллагааг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрс сайжруулах шаардлагатай болжээ.

Аймаг, орон нутагт Монгол улсын химийн чиглэлийн олон улсын конвенц, түүнийг хэрэгжүүлэхээр үндэсний хэмжээнд хүлээсэн үүрэг, НҮБ-ын төрөлжсөн байгууллагад гаргаж өгөх мэдээ, бүртгэлийн талаар ойлголцогүй байна.

Дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай санал.

1. Улсын хэмжээнд химийн бодис хууль бусаар ашиглан алт олборлох буй иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь 8 аймгийг хамарч, 200 мянга орчим тонн шлам, 37,35 га талбай мөнгөн усаар бохирдож, ялангуяа говийн болон төвийн бүсэд хүн, мал, амьтны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, байгаль орчинд сөргөөр нөлөөлөх бодит нөхцөл бүрдсэнийг онцгойлон анхаарч, аюулгүй болгох арга хэмжээг яаралтай авах болсон байна.

2. Химийн бодис нэвтрүүлдэг хилийн боомтууд болон төр боомтууд дээр гаалийн мэргэжлийн байцаагч, шалгах багаж хэрэгсэл, шинжлэх лабораторийн хүчин чадал байхгүйгээс химийн бодист тавих хилийн хяналт сул, шаардлага хангахгүй байгаа нь хилээр хууль бусаар химийн бодис нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Бороо голын сав газарт хуримтлагдсан үүсмэл мөнгөн усны эх үүсвэрийг хамгаалалтанд авч, олон улсын байгууллагын тусламжаар хоргүйжүүлэх арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байна.

4. Хүн, мал, амьтны эд эрхтэн болон тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоонд мөнгөн ус, бусад хүнд металл, цианид зэрэг химийн хорт болон аюултай бодисын тоо болон чанарын үзүүлэлтийг олон улсын стандартын түвшинд тодорхойлох лабораторийн нарийн мэдрэмж бүхий багаж, тоног төхөөрөмж дутагдалтай байна.

5. Химийн хорт болон аюултай бодисын үлдэгдэл, хаягдлыг хоргүйжүүлэн устгах зориулалтын байгууламжийг ойрын хугацаанд нийслэлд болон бүсийн төвүүдэд бий болгох шаардлагатай байна.

6. Химийн болон хүнсний аюулгүй байдлыг хангах, хортой, аюултай бодисын хэрэглээг зохицуулах, хордлогоос хүн амыг хамгаалах талаар хуулиар олгогдсон эрх, үүргээ аймаг, орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтан хэрэгжүүлэхгүй, хордлого, бохирдол үүсгэх боломж олгосон этгээдтэй хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцохгүй орхигдуулснаас мөнгөн ус, цианидын хууль бус хэрэглээг өргөжүүлэхэд хүргэсэн байна.

7. Химийн осол гарч онцгой нөхцөл байдал үүсэхэд төрийн захиргааны төв байгууллагууд болон төрөлжсөн мэргэжлийн байгууллагууд хоорондын ажлын уялдаа сул, хэрхэн хамтран ажиллаж үүссэн эрсдэл, хордлогыг аюулгүйжүүлэх аргачлал бүхий менежментийн бодлого, төлөвлөгөөгүйгээс төв, орон нутгийн аль ч түвшинд бэлэн бус байгаа нь химийн жижиг ослын хор уршгийг арилгахын тулд яам, агентлагууд тус тусдаа нэгдмэл биш салангид арга хэмжээ зохион байгуулж буй нь оновчтой бус байна.

8. Дархан-Уул аймгийн Хонгор сумын төвд үүссэн бохирдлыг хоргүйжүүлэн саармагжуулах шаардлагатай арга хэмжээг бүрэн хийж, хүн, мал, амьтан эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл хэвийн байдалдаа орсон боловч ослын үеэр болон нууцаар ашигласан мөнгөн усны сөрөг нөлөөлөл удаан хугацаанд үйлчлэх магадлалтайг анхаарч иргэд, аж ахуйн нэгж, төр, захиргааны болон олон нийтийн байгууллагууд хамтран бодитойгоор асуудалд хандаж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх нь чухал болоод байна.

9. Химийн аюулгүй байдлыг хангах урт хугацааны төрийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, байгаль орчинд хор, аюул учруулж байгаа болон нөхцөл боломжийг бусдад олгосон буруутай иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай тооцох хариуцлагыг чангатгах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсний төлбөрийг буруутай этгээдээр төлүүлж, доройтож, бохирдсон байгаль орчыг нөхөн сэргээх, хоргүйжүүлэн саармагжуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр шинээр хууль гаргах буюу эрүүгийн болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах бодит шаардлагатай болсон байна.

10. Химийн бодисын үлдэгдэл, хортой, аюултай хог хаягдлын хуримтлал үйлдвэр, үйлчилгээний байгууллагад бий болж олон жил хадгалагдаж байгаа нь бас нэг аюулын эх үүсвэр болж байна.

Б. Ойрын хугацааны зорилт

Химийн хор аюулаас сэргийлэх, үр дагаврыг арилгах зорилгоор ойрын хугацаанд дор дурьдсан ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Есөн аймгийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан мөнгөн ус, цианидаар бохирдсон 200 мянган тонн шлам, мөнгөн усаар бохирдсон 37.35га талбай, цианид, мөнгөн усаар бохирдсон 10 гаруй га талбайг хоргүйжүүлэн саармагжуулж, булшлах
2. Химийн лабораториудын өнөөгийн түвшинг үнэлж, тоног төхөөрөмжийн болон боловсон хүчний чадавхийг сайжруулах саналыг боловсруулж, Засгийн газарт оруулах
3. Хөрс, усны стандартыг шинэчлэх, агаарын стандартыг шинээр боловсруулан, мөнгөн ус, цианид, хартугалга гэх мэт онцгой хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг шинэчлэн тогтоох
4. Эрхзүйн орчныг боловсронгуй болгон, цианид болон арьс ширний үйлдвэрт хэрэглэгддэг химийн бодисыг импортлох "онцгой" эрхийг тендерээр шалгаруулах замаар цөөн тооны компанид олгох боломжийг судалж шийдвэрлэх
5. Химийн бодисын хэрэглээнд хяналт тавих мэргэжлийн яамд (ҮХЯ, ХХААЯ, ЭМЯ), агентлаг (УМХГ, ОБЕГ, ТЕГ, ЦЕГ), иргэдийн оролцоог нэмэгдүүлэх механизм бүрдүүлэх
6. Мэргэжлийн боловсон хүчнийг бүрдүүлэх бололцоог хангана.
7. Химийн тооллогыг боловсронгуй болгох асуудлыг судлах
8. Химийн бодисын хууль бус хэрэглээг тус яамнаас зөвшөөрөл аваагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдээгүй аж ахуйн нэгж, иргэд үйлдэж байгааг анхааралдаа авч, хилийн мэргэжлийн болон гаалийн хяналтыг сайжруулах, үндсэн ордод гар аргаар алт олборлохыг хориглох зэрэг арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байна.

3 дугаар хавсралт

Монгол улсад хэрэглэхийг хориглосон хортой,
аюултай химийн бодисын хэмжээ

д/д	Аймаг, нийслэлийн нэр	Альдрин	Гексахлор бензол	Дильдрин	Нэр төрлийн тоо	Хэмжээ, кг	Эзлэх хувь, %
1.	Архангай						
2.	Баян-Өлгий						
3.	Баянхонгор						
4.	Булган						
5.	Говь-Алтай						
6.	Говьсүмбэр						
7.	Дархан-Уул						
8.	Дорнод						
9.	Дорноговь						
10.	Дундговь						
11.	Завхан						
12.	Орхон						
13.	Өвөрхангай						
14.	Өмнөговь						
15.	Сүхбаатар						
16.	Сэлэнгэ						
17.	Төв						
18.	Увс						
19.	Ховд						
20.	Хөвсгөл	15		3.0	2	18.0	97.3
21.	Хэнтий						
22.	Улаанбаатар		0.5		1	0.5	2.7
	Бүгд	15.0	0.5	3.0	3	18.5	100.0

2008-2012 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажлын товч агуулга	Хугацаа, оноор	Хариуцан гүйцэтгэгч
1.	2007 оны улсын химийн тооллогын нэгдсэн дунд судалгаа хийж, сайжруулах арга хэмжээг боловсруулах, байгаль орчны албадыг мэргэжлийн боловсон хүчинээр хангах асуудлыг судлах, тооллогыг бүртгэлтэй болгох дүнднээс тооллого хийх бүртгэлийн хуудсыг боловсронгуй болгох, тооллогыг нэгдсэн системд оруулах	2008 оны 2-3 сар	БОЯ, Химийн үндэсний хороо,
2.	Монгол Улсын үндэсний Химийн Менежментийн бодлогыг олон улсын жишигт тохируулан боловсруулж, сайдын зөвлөл, Засгийн Газрын хурлаар оруулан батлуулах	2008 оны 3-5 сар	БОЯ, Химийн үндэсний хороо,
3.	Химийн хортой болон аюултай бодисын улсын үзлэг тооллогыг 2 жил тутамд тогтмол явуулж нэгдсэн дүнг гарган аймаг хотын Байгаль орчны, мэргэжлийн, онцгой байдлын албад болон химийн мэргэжилтнүүдийн семинар сургалтыг зохион байгуулж тогтмолжуулах	2009, 2011 оны 6-9 сар	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
4.	Монгол улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан, мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон их хэмжээгээр хуримтлагдсан, химийн бодисыг аюулгүй болгох, устгах асуудлыг судалж дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулан ажиллуулах	2008 оны 5-7 сар 2010, 2012 он	Химийн үндэсний хороо, Шинжээчийн баг
5	Аймаг, хотын БО-ы хяналтын албадыг мэргэжлийн химичийн орон тоотой болгон ажиллуулж тухайн нутаг дэвсгэрт хэрэглэж байгаа химийн бодисын мониторингийн асуудлыг хариуцуулах	2008-2009 он	БОЯ, УМХГ
6	Улсын хэмжээгээр хэрэглэгдэж байгаа химийн бодисын хор аюулын зэрэг, хоргүйжүүлэн саармагжуулах аргын талаархи лавлагааны материалуудыг багтаасан гарын авлагыг хэвлүүлэн гаргаж ашиглуулах	2008 он	БОЯ, Химийн үндэсний хороо
7	Химийн хортой аюултай бодисын шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг лабораториудыг нэгдсэн нэг удирдлагад төвлөрүүлэн хүчин чадлыг нь дээшлүүлэн нарийн багаж төхөөрөмж, боловсон хүчнийн чадавхийг сайжруулах санал боловсруулж Засгийн газарт оруулах	2008-2009 он	БОЯ, Химийн үндэсний хороо
8	Химийн мэргэжилтэн бэлтгэдэг гол их сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд химийн хортой аюултай бодисын шинж чанар, ашиглалт, аюулгүй ажиллагааны талаар хичээл оруулах асуудлыг шийдвэрлэх	2009 он	БОЯ, Химийн үндэсний хороо
9	Химийн бодисын ашиглалт зарцуулалтын анхан шатны бүртгэл хөтөлж уг бодисыг эзэмшигч, ашиглагч, болон худалдан авагчийн талаар манифест буюу дагалдах баримт бичгийг нээж хийж, химийн бодисыг анх хүлээн авахдаа түүний хор аюулын талаар лавлах мэдээллийг бүрдүүлж, импортлох зөвшөөрөл авдаг зарчмыг аж ахуйн нэгж байгууллага, хэрэглэгчдийн түвшинд бүрэн хэвшүүлэх	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
10	Хортой аюултай бодисын үлдэгдэл хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулан устгах нарийвчилсан заавар боловсруулан нийслэл болон аймгийн төвүүдэд хортой хог хаягдал, химийн бодисыг саармагжуулан хоргүйжүүлэх технологитой цэг байгуулж тогтмол ажиллуулах	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
11	Химийн бодисын үндэсний ангилал болон Монгол	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ,

	улсад хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан бодисын жагсаалтад тодотгол хийх ажлыг 2 жил тутамд тогтмолжуулах		Химийн үндэсний хороо,
12	Химийн хортой аюултай бодисын аюулын тухай болон түүний уршгаар осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар телевиз радио бусад мэдээллийн хэрэгслээр сурталчилна	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
13.	9 аймгийн нутаг дэвсгэрт хуримтлагдсан мөнгөн ус, цианидаар бохирдсон шлам мөн мөнгөн усаар бохирдсон талбайг хоргүйжүүлэн саармагжуулж булшлах ажлыг зохион байгуулна.	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
14.	Хөрс усны стандартыг шинэчлэх, агаарын стандартыг шинээр боловсруулан мөнгөн ус, цианид, хар тугалга гэх мэт онцгой хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг шинэчлэн тогтоох	2008-2012	БОЯ
15.	Мөнгөн усыг ашигт малтмалын олборлолт, болон боловсруулалтад ашиглахыг хатуу хориглох тухай Засгийн газрын тогтоол гаргуулан мөрдүүлэх,	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,
16.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд хүнсний болон химийн аюулгүй байдлын асуудлаар нарийн мэргэжлийн шинжээч-үнэлгээний багийг /орон тооны бус/ байгуулж, шаардлагатай үед мэргэжлийн зөвлөмж дүгнэлт гаргуулдаг байх тогтолцоо бүрдүүлэх	2008-2012	БОЯ Химийн үндэсний хороо,
17.	Аюултай хог хаягдал, Химийн бодисын зөв бус ашиглалт, тээвэрлэлт, устгалыг мэдээлэх нээлттэй утас ОБГ-т ажиллуулах	2008-2012	БОЯ, ОБЕГ, ҮХЯ, Химийн үндэсний хороо,

**Мэдээлэл цуглуулах ажиллагааны
хавсралт илтгэх хуудас №1**

МӨНГӨН УС БОЛОН ЦИАНИТ НАТРИЙН ТУХАЙ

Монгол Улсад түгээмэл хэрэглэгддэг химийн хорт бодис болох мөнгөн ус, цианит натри түүний хор, хөнөөлийн тухай товч танилцуулвал:

Д/д	Химийн хорт бодисын нэр	ОУ-ын бүртгэлийн дугаар	Түгээмэл ашигладаг салбар	Хор, аюул
1.	Мөнгөн ус	7439-97-6	Багаж тоног төхөөрөмж, уул уурхай /алт бариулах/, пестицидэд хэрэглэдэг	Мэдрэл, бөөр, ураг, зүрх судасны системд муугаар нөлөөлдөг. Хавдар үүсгэдэг
2.	Цианит натри	57-12-5	Цахилгаан химийн үйлдвэрлэл, металл цэвэрлэх, уул уурхайд хэрэглэдэг	Хүний биед онцгой хортой ба бага хэмжээгээр амьсгалах, залгихад үхэлд хүргэнэ. Мэдрэлийн болон нөхөн үржлийн системд сөргөөр нөлөөлдөг

БОЯ-аас натрийн цианид импортлох, ашиглах зөвшөөрөл авсан уул уурхайн компаниуд

	Компаний нэр	Байршил	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрөл авсан хэмжээ, хугацаа		Тайлбар
				2007 оноос өмнө	2007	
1	Бороо гоулд ХХК	Сэлэнгэ аймаг, Баянгол сум.	Импортлох-ашиглах	2003 он-1400 тн/жил 3 жил	2007 он- 800тн 1 жил 2007 он- 800тн 1 жил	Нуруулдан уусгах технологит
2	Бумбат ХХК	Төв аймаг, Заамар сум	Импортлох-ашиглах	2003 он - 155тн/жил 3 жил		Үйл ажиллагаа нь зогссон
3	Цагаан цахиур гоулд ХХК	Баянхонгор Баян-Овоо	Импортлох-ашиглах	2004 он -5 тн/жил 3 жил		Зөвшөөрлийг хүчингүй болгосон
4	Эм Жи Эйч ХХК	Өмнөговь аймаг, Олон овоот	Импортлох-ашиглах	2005 он -129 тн/жил 6 сар 2006 он – 277.2 тн/жил 1 жил	2007 он- 36 тн 1 жил	
5	Гүн билэг трэйд ХХК	Төв аймаг, Борнуур сум	Импортлох-ашиглах	2тн 3 жил		Хугацаа дууссан
6	Капитал ресурсес ХХК	Сэлэнгэ аймаг, Баянгол сум	Импортлох-ашиглах	3тн 3 жил		Хугацаа дууссан
7	Их хан уул ХХК	Баянхонгор	Импортлох-ашиглах	3тн 2006 онд 5 сар		Хугацаа дууссан
8	Сонголд ХХК	Сэлэнгэ аймгийн Мандал сум	Импортлох-ашиглах	0.6тн		Хугацаа дууссан

УИХ.МН
БУДАЛГААНЫ САН

**Мэдээлэл цуглуулах ажиллагааны
илтгэх хуудас №1**

хавсралт 2

9	Бумантрейд ХХК	Өмнөговь аймаг, Ханбогд сум	Ашиглах	2006 он- 2тн 1 жил	2007 он- 5.2тн 1 жил	2006 онд сар гаруй ажилласан. 2007 онд ажиллаагүй
10	Тэн хун ХХК	Төв аймгийн Жаргалант сум	Импортлох- ашиглах		2007 он 25тн 1 жил	
	Нийт			5106.8тн	1665.2 тн	

Мөнгөн ус ашиглах зөвшөөрөл авсан компани

№	Компанийн нэр	Байршил	Хугацаа	Захиалагч байгууллага	Тайлбар
1	Балчулуу ХХК /Шинжлэх ухаан технологийн төсөл/	Сэлэнгэ аймгийн Баянгол сум, Цагаанчулуутын ам.	2003-2005 он	ҮХЯ	Хугацаа дууссан

UIH.MN
СУДАЛГААНЫ САН